



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 42

Арвайхээр


Мотоциклийн хөдөлгөөнийг түр
хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9.2 дахь, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 06/03 дугаар тогтоолоор батлагдсан “Хотын дүрэм”-ийн 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор тус сумын хэмжээнд 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 2018 оны 2 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд цас орсон, халтиргаа, гулгаа үүссэн нөхцөлд мотоциклоор зорчихыг түр хориглосугай.

2. Мотоциклоор зорчихыг хориглох бүсийг /төвийн бүх засмал зам/ хавсралтаар баталсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавиж, илэрсэн зөрчлийг арилгуулах, ард иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлэг өгч сурталчилахыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан шуурхай хүргэж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа /О.Ганбат/, сумын Засаг дарга /О.Пүрэвдорж/ нарт, тогтоолын хэрэгжилт, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд 2018 оны 03 дугаар сард танилцуулахыг Замын цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад /Д.Гомбосүрэнжав/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Д.АМАРТҮВШИН